

МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 5 дугаар сар

- Мөнгөний нийлүүлэлт 5 дугаар сард 4.3%-иар өсч 12.9 их наяд төгрөг болов.
- Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өмнөх сард буурч 18.0% байсан бол тайлант сард 21.5% болов.
- 2017 оны эхнээс төгрөгийн харилцах, хадгаламж өсч, валютын харилцах, хадгаламж буурч байсан бол тайлант сард байгууллагын валютын харилцах, хадгаламж өсөлттэй гарлаа.
- Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, банкуудын касс дахь бэлэн мөнгө болон Төв банк дахь харилцах өссөнөөр нөөц мөнгө өсч 3.0 их наяд төгрөг болов.
- Нийт хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдлийн өсөлт тайлант сард саарч нийт дүн нь 12.7 их наяд төгрөгт хүрэв. Үүний 52.1 хувь нь хувийн хэвшилд, 46.8 хувь нь иргэдэд олгосон зээл байна.
- Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлийн 7.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 9.1 хувь нь чанаргүй зээл байна.
- ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг Монгол улсад хэрэгжүүлэхээр болсонтой холбогдуулан эхний ээлжийн 38.6 сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний санхүүжилт Монголбанкинд орж ирэв.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

		2016			2017		
		12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар
Инфляци							
Улаанбаатар хотын	сарын	0.9	0.9	0.6	1.6	1.5	0.6
	оны эхнээс	0.5	0.9	1.6	3.2	4.8	5.4
	жилийн	0.5	1.7	1.8	3.0	3.2	3.8
Суурь	сарын	0.3	0.1	0.1	0.7	0.9	0.5
	оны эхнээс	0.5	0.1	0.2	0.9	1.8	2.6
	жилийн	0.5	-0.1	2.1	2.8	3.6	4.5
Улсын	сарын	0.7	0.9	0.8	1.2	1.1	0.3
	оны эхнээс	1.1	0.9	1.7	2.9	4.1	4.4
	жилийн	1.1	2.3	2.6	3.4	3.4	3.7
Мөнгө, санхүүгийн сектор							
Нөөц мөнгө, сая ₮		3,487,656.0	2,712,102.5	2,675,173.0	2,749,861.6	2,779,941.0	2,984,657.4
сарын өөрчлөлт, хувиар		-1.7	-11.5	-1.4	2.8	1.1	7.4
жилийн өөрчлөлт, хувиар		38.4	17.5	15.9	17.0	-7.0	-6.9
M2 мөнгө, сая ₮		12,076,501.7	11,880,661.8	12,257,201.8	12,189,513.0	12,411,887.6	12,944,335.4
сарын өөрчлөлт, хувиар		3.0	-1.6	3.2	-0.6	1.8	4.3
жилийн өөрчлөлт, хувиар		20.2	20.6	22.4	20.5	18.0	21.5
Бусад хадгаламж, сая ₮		9,986,377.6	9,928,266.8	10,112,179.4	10,106,418.9	10,140,089.7	10,497,110.3
сарын өөрчлөлт, хувиар		1.9	-0.6	1.9	-0.1	0.3	3.5
жилийн өөрчлөлт, хувиар		19.4	20.5	19.1	18.5	14.8	17.8
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮		823,629.3	736,068.2	944,705.5	788,251.9	834,150.2	875,421.5
сарын өөрчлөлт, хувиар		7.1	-10.6	28.3	-16.6	5.8	4.9
жилийн өөрчлөлт, хувиар		16.6	3.1	44.1	19.7	12.0	11.0
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮		12,422,235.9	12,379,495.2	12,583,529.0	12,678,043.4	12,706,689.3	12,711,037.8
сарын өөрчлөлт, хувиар		-2.3	-0.3	1.6	0.8	0.2	0.0
жилийн өөрчлөлт, хувиар		6.1	5.0	8.1	7.1	9.2	11.0
Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮		1,051,680.5	1,056,150.4	1,070,100.6	1,035,475.9	1,087,258.3	1,158,298.4
сарын өөрчлөлт, хувиар		-9.9	0.4	1.3	-3.2	5.0	6.5
жилийн өөрчлөлт, хувиар		20.9	18.1	17.5	7.0	1.3	9.0
Мөнгөний үржүүлэгч		4.0	4.4	4.6	4.4	4.5	4.3
Банк хоорондын зах							
Илүүдэл нөөц, сая төгрөгөөр		-24.0	-62.9	-36.5	-58.7	-23.8	-32.3
сарын өөрчлөлт, хувиар		50.3	-162.3	42.1	-60.9	59.4	-35.6
Илүүдэл нөөц - Байнгын санхүүжилт		-5,955.0	-39,316.6	5,823.3	-24,819.1	-12,738.5	3,342.2
сарын өөрчлөлт, хувиар		81.4	-560.2	114.8	526.2	48.7	126.2
Илүүдэл нөөц - ТБ-ны буцах санхүүжилт + ON + ТБҮЦ		530,470.2	329,615.4	510,237.6	895,349.6	1,166,964.2	1,288,816.8
сарын өөрчлөлт, хувиар		-40.0	-37.9	54.8	75.5	30.3	10.4
Хөтөлбөрийн зээл, сая төгрөгөөр		1,055,552.2	1,059,646.1	1,089,575.6	1,113,543.9	1,149,788.3	1,162,401.4
Хүү (хувиар)							
Хадгаламжийн ЖДХ		13.1	13.4	13.3	13.0	13.0	12.8
Хадгаламжийн бодит хүү*		12.6	11.7	11.5	10.0	9.7	9.0
Зээлийн ЖДХ**		19.7	20.2	20.1	20.2	20.0	20.4
Зээлийн бодит хүү*		19.2	18.4	18.3	17.2	16.8	16.5
Ипотекийн зээлийн хүү		10.3	9.6	10.3	10.3	10.5	10.3
ТБҮЦ-ны ЖДХ		14.5	14.0	14.0	14.0	14.0	14.0
Бодлогын хүү		14.0	14.0	14.0	14.0	14.0	14.0
БХЗ-ын ЖДХ		15.5	14.5	14.9	15.0	15.0	14.7

* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

** Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

М2 мөнгөний нийлүүлэлтийн 52.8%-ийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 17.4%-ийг валютын хадгаламж, 14.0%-ийг төгрөгийн харилцах бүрдүүлж байна.


М2 мөнгөний жилийн өсөлт 2017 оны 2 дугаар сараас хойш буурч 4 дүгээр сард 18.0%-д хүрээд байсан бол 5 дугаар сарын эцэст 21.5% болж өсөв. Жилийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн хадгаламж, харилцахын өсөлт бүрдүүлж байна.

Тухайн сард М2 мөнгөний нийлүүлэлт 4.3% (532.4 тэрбум төгрөгөөр)-иар өсч 12.9 их наяд төгрөгт хүрэв. Үүнд бусад хадгаламж, харилцах 3.5% (357.0 тэрбум)-иар, М1 мөнгө 7.7% (175.4 тэрбум)-иар өссөн нь нөлөөлөв.


Бусад хадгаламж, харилцахын бүрэлдэхүүн хэсгүүдээс төгрөгийн хадгаламж 290.9 тэрбум төгрөгөөр, валютын харилцах 112.9 тэрбум төгрөгөөр тус тус өсч, валютын хадгаламж 46.9 тэрбум төгрөгөөр буурсан байна.

М1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 136.5 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 38.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 1. М2 жилийн өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)



Зураг 2. М2 сарын өсөлтийн задаргаа (эх үүсвэрээр)




Зураг 3. М2 сарын өөрчлөлт, тэрбум ₮



Гадаад валютын хадгаламжийн нийт хадгаламжид эзлэх хувь 2017 он гарснаас хойш буурсаар 24.7%-д хүрлээ. Энэ нь сүүлийн саруудад төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн чангаралттай холбоотойгоор иргэд төгрөгөөр хадгаламж байршуулахыг илүүд үзэж байгаа болон валютын хадгаламжийн төгрөгөөр илэрхийлэгдэх дүн буурч байгаатай холбоотой байна.

Тайлант сард иргэдийн гадаад валютын хадгаламж 6.3%-иар буурсан бол байгууллагын валютын хадгаламж 23.7%-иар өсчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол иргэдийн гадаад валютын хадгаламж өмнөх сараас ойролцоогоор 5.5%-иар буурсан бол, байгууллагынх 24.8%-иар өссөн байна.

Зураг 4. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)




Гадаад, дотоод актив

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив өмнөх сараас 521.5 тэрбум төгрөгөөр, гадаад цэвэр актив 10.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад цэвэр актив өмнөх сараас 267.8 сая төгрөгөөр буурч, бусад хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив 104.1 тэрбум төгрөгөөр өссөн бол ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 92.7 тэрбум төгрөг (38.6 сая ам.доллар) –ийн зээлийн санхүүжилт орсон нь нөлөөлөв.

Дотоод цэвэр авлага өмнөх сараас 45.1 тэрбум төгрөгөөр буурч 17.3 их наяд төгрөг болжээ. Иргэдээс авах авлага 100.0 тэрбум төгрөгөөр, Засгийн газраас авах цэвэр авлага 50.9 тэрбум төгрөгөөр буурсан бол улсын байгууллагаас авах авлага 51.1 тэрбум төгрөгөөр, хувийн хэвшлээс авах авлага 45.7 тэрбум төгрөгөөр, бусад санхүүгийн

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



байгууллагаас авах авлага 8.1 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Тайлант сард нөөц мөнгө 204.7 тэрбум төгрөгөөр өсч 2984.7 тэрбум төгрөг болжээ. Банкуудын Төв банк дахь харилцах 163.1 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 38.9 тэрбум төгрөгөөр, банкуудын касс дахь мөнгө 2.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 6. Нөөц мөнгө



Хадгаламжийн байгууллагын зээлийн үлдэгдэл


Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 4.3 тэрбум төгрөгөөр өсч 12.7 их наяд төгрөг болжээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 52.1 хувийг хувийн хэвшилд, 46.8 хувийг иргэдэд, 1.1 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.


Нийт зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сарын түвшинд буюу 7.3 хувьд байна. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.5 нэгж хувиар нэмэгдэж 9.1 хувьд хүрэв. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.6 хувийг эзэлж байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн 84.1 хувь, чанаргүй зээлийн 80.5 хувь нь хувийн хэвшилд олгосон зээл байна.

Зураг 7. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Зураг 8. Хадгаламжийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 815.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 67.7 хувийг овернайт зээл, 16.1 хувийг репо арилжаа, 14.8 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 1.4 хувийг банк хоорондын хадгаламж тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2017 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 5 дугаар сарын 23-ны өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах, төлбөр тооцоо, гүйлгээний зорилгоор 2249.4 тэрбум төгрөгийг Монголбанк дахь төгрөгийн харилцахад, 1608.7 тэрбум төгрөгтэй тэнцэх валютыг валютын харилцах дансанд тус тус байршуулжээ.

Тайлант сард олгосон болон үлдэгдэлд жигнэсэн төгрөгийн зээлийн хүү өмнөх сараас өсч харгалзан 20.4%, 18.7% болжээ. Харин тайлант сард олгосон валютын зээлийн хүү 1.0 нэгж хувиар буурч 12.1%-д хүрсэн бол үлдэгдлээр жигнэсэн валютын зээлийн хүү өмнөх сарын түвшинд буюу 11.9%-тай байна.

Тайлант сард төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн дундаж хүү өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурч 12.8% болсон бол тухайн сард татсан хадгаламжийн хүү 0.5 нэгж хувиар өсч 13.2%-д хүрчээ. Гадаад валютын хадгаламжийн хүү бага зэрэг буурч 5.8%-д хүрсэн бол тухайн сард татсан валютын хадгаламжийнх 2.8 нэгж хувиар өсч 7.1% болжээ.

Зураг 9. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү
Тэрбум ₮




Хүү

Зураг 10. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 11. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү




Валютын ханш

2017 оны 5 дугаар сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 0.9 хувь буюу 21.5 төгрөгөөр чангарч 2398.0 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2413.1 төгрөг байв. 2017 оны 5 дугаар сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2682.1, Хятадын юаньтай харьцах ханш 351.1, ОХУ-ын рубльтай харьцах ханш 42.3 байв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 0.8%-иар өссөн буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр чангарав.

Зураг 12. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100



Инфляци

Зураг 13. Улаанбаатар хотын сарын инфляци

2017 оны 5 дугаар сарын инфляци УБ хотын хэмжээнд 0.6 хувь байгаагаас 0.4 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 0.2 нэгж хувийг хүнсний бараа үйлчилгээ бүрдүүлжээ. Хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өссөн нь голчлон тээвэр, хувцас бөс барааны бүлгийн өсөлтөөс шалтгаалсан байна. Харин хүнсний барааны үнэ өмнөх сараас 0.8 хувиар өссөнд мах, махан бүтээгдэхүүний үнэ 1.6 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.



Зураг 14. Улаанбаатар хотын жилийн инфляци

Жилийн инфляци УБ хотын хэмжээнд 2017 оны 5 дугаар сарын байдлаар 3.8 хувь байгаагийн 3.1 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 0.7 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

